

АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2024 ОНЫ БИЕЛЭЛТ

2024.12.15

Дэлүүн сум

д/д	Шалгуур үзүүлэлт	Биелэлт	Үнэл-гээ
Нэг: ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ			
1.1.1	Сумын нутаг дэвсгэрт байгаа түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалалтад авч, сэргээн засварласан байна.	Сумын нутаг дэвсгэрт орших аймгийн хамгаалалтад байгаа түүх, соёлын дурсгалт газруудын бүрэн, бүтэн байдалд хяналт тавьж, . хамгаалалтад авч ажиллаж байна. Тухайн газар нутгийн онцлогийг харгалзан үзэж орон нутгийн иргэдэд хариуцуулан хамгаалуулах гэрээ байгуулсан болно. Хагас, бүтэн жилээр урамшуулах механизм бий болгон 5 хүнтэй шинээр гэрээ байгуулан ажиллаж байна.	80%
1.1.2	Сумын номын сангийн хүртэмжийг нэмэгдүүлэх.	Сумын номын сангаас тайлант хугацаанд сумын хөдөөгийн алслагдсан 3 багт 97 ш номыг зөөврөөр олгож, 138 гаруй уншигчийг номын сангийн үйл ажиллагаанд хамруулав. Номын сангийн хөмрөгийн бүрдүүлэлт болон данс бүртгэлийг журмын дагуу хөтөлж байна.	90%

		Жилийн хугацаанд 1,0сая төгрөгөөр уншигчдын эрэлт хэрэгцээг хангахуйц уран зохиолын болон хүүхдийн ном зохиолоор фондоо баяжуулсан болно. Сэлбэн зассан номын тоо -67 Олгосон номын тоо- 3375 Уншигчдын тоо – 2218 Үйлчлүүлэгчдийн тоо- 2539 Шинээр авсан номын тоо - 62	
ХОЁР: ХҮНИЙ ХӨГЖИЛ 2.1 Чанартай боловсрол			
2.1.1	Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшлах боловсон хүчний нөөцийн судалгааг нарийвчлан гаргаж, багшийн мэргэшүүлэх, давтан сургах замаар ур чадварыг дээшлүүлсэн байна.	Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтууд 1,5,10 жил гэсэн тусгай хөтөлбөрийн дагуу тогтмол явагдаж байгаа, мөн жил бүрийн 12 дугаар сард багш нар цахим сургалтад хамрагдаж , мэдлэг , чадвараа дээшлүүлэн ажиллаж байгаа.	100%
2.1.3	Сургуулийн өмнөх боловсролын хамран	Хүүхдийн 1-р цэцэрлэг нь 2024 оны 12-р сард Дэлүүн сумын	100%

	сургалтыг нэмэгдүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулан, хүүхдийн авьяасыг илрүүлэн хөгжүүлнэ.	Хүүхдийн 2,3 дугаар цэцэрлэгийн багш нартай хамтарч сайн туршлага үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэв. Хүүхдийн 2-р цэцэрлэг нь 2024 оны 11-р сард Дэлүүн сумын 1-р цэцэрлэгийн багш нартай туршлага солилцож хичээл үйл ажиллагаа явуулв.	
2.1.4	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарыг ахиулан, чанарын үнэлгээний тогтолцоог нэвтрүүлж, элсэлтийн ерөнхий шалгалтын дүнд ахиц гаргана.	Сургалтын чанарыг ахиулахад чиглэсэн багш болон сургалтын байгууллагыг боловсролын үнэлгээнээс үнэлдэг үнэлгээний систем нэвтэрсэн. Элсэлтийн ерөнхий шалгалтаас амжилт гарган ажиллахыг жил болгон зорилго болгон ажиллаж байгаа болно..	100%
2.1.5	Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.	Ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулсан ч, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй. Сургуулийн өмнөх боловсролын урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллаж байна.	50%
2.1.7	Сургууль, цэцэрлэгт сурч боловсрох ээлтэй орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, шаардлагатай дотуур байр, цэцэрлэгийг шинээр барих.	Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд нэлээн анхааран ажиллаж байна. 2023-2024 оны хичээлийн жилд 320 хүүхдийн хичээлийн байрны хоёр коридорт хүүхэд хөгжлийн төвийг шинээр нээж, таатай орчин бүрдүүлсэн. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг сургалтанд хамруулах чиглэлээр аймгийн Засаг даргын	100%

		захирамжаар шинээр 3 дугаар цэцэрлэг байгуулагдаж 33 хүний ажлын байр, 200 гаруй хүүхдийг сурган хүмүүжүүлэх боломж бүрдсэн болно.	
2.2 Эрүүл мэнд			
2.2.1	Эмнэлгийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргаж эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шилдэг менежментийг нэвтрүүлнэ.	Эмнэлгийн үйлчилгээг сайжруулж, шинэ түвшинд хүргэх менежментийн шилдэг туршлагыг судлан, нэвтрүүлж байгаа. Сэргээн засах тасаг, халдвартын тасаг шинээр нэмэгдсэн. Ард иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлж байгаа.	90%
2.2.2	Халдварт бус өвчний эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээг сайжруулна	Халдварт бус өвчний эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээг цаг тухайд нь хийж ажиллаж байгаа.	80%
2.2.3	Эрүүл мэндийн байгууллагын дэд бүтцийг сайжруулан, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж хатуу зөөлөн эдлэл, сумын ОНХСангийн хөрөнгө оруулалтаар зөөлөн эдлэлээр бүрэн хангагдсан. Аймгийн Орон нутгийн төсвийн 170.0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хуучин эмнэлэгт урсгал засвар хийгдэж байгаа.	90%

2.2.4	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангуулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангуулж, хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байгаа.	80%
2.2.5	Эрүүл мэндийн яаралтай тусламжийн чанар, аюулгүй байдлыг хангуулж, хүртэмжийг сайжруулна.	Эрүүл мэндийн яаралтай тусламжийн чанар, аюулгүй байдлыг хангуулж, хүртэмжийг сайжруулан ажиллаж байгаа.	80%
2.2.6	Эх, хүүхэд ээлтэй орчин бүрдүүлэн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна	Эх, хүүхэд ээлтэй орчин бүрдүүлэн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан эх, хүүхдийн эндэгдлийг бууруулан ажиллаж байгаа.	90%
2.3 Хөдөлмөр эрхлэлт			
2.3.1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах бодлого боловсруулж, орон нутгийн онцлогт нийцүүлэн зохион байгуулж, ажилгүйдлийг бууруулна.	Еjob программд ажилгүй иргэдийн судалгааг шивснээр иргэд түр болон байнгын ажилд зуучлагдаж ажилгүйдлийн түвшин буурах боломж бүрдэж байна.	100%
2.3.2	Ажилгүй, мэргэжилгүй, ажилгүйдэлд өртөж болзогүй иргэдийг мэргэжил олгох	Багийн засаг дарга нартай хамтарч ажилгүй иргэдийн судалгааг хийж 2 хүнийг мэргэжил олгох сургалтад хамруулж	100%

	сургалтад хамруулан мэргэжил эзэмшүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулж, ажил олгогч байгууллагуудаас ирсэн захиалгын дагуу ажилд зуучлана.	3 иргэнийг байнгын асаргаанд, 65 иргэнийг түр ажлын байранд зуучлав.	
2.3.3	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх таатай орчинг сайжруулна	Ажиллуулсан иргэддээ холбогдох мэргэжилтнүүдтэй хамт ХАБ-ын зааварчилгаа өгч, ХАБ –н хэрэгсэл олгож ажиллав.	100%
2.3.4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 1 иргэнийг хамруулж 4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгов.	100%
2.4 Гэр бүл, хүүхэд хамгаалал			
2.4.1	Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.	Сумын Засаг даргын захирамжаар “Хүүхдийн төлөө зөвлөл” ба бүх байгууллага тус бүрд “Эцэг эхийн зөвлөл” болон Ерөнхий боловсрол 1-р сургуулийн “Хүүхэд хамгааллын баг” нийт 1370 сурагчийн асран хамгаалж буй эцэг эхтэй, сургуулийн нийт багш ажилчид “Ёс зүйн гэрээ” тус тус хийсэн байна. Сумын ерөнхий боловсролын 1, 2, 3 сургуулийн сурагчид Олон улсын Казак хэлний уралдаанд оролцож 2-р байранд орсон байна.	100%

		Соёл урлаг болон биеийн тамирын төрөл бүрийн тэмцээнд оролцож эхний байранд нийт 20 хүүхэд эзэлсэн байна.Сумын дотуур байрны нийт 70 багш ажилчдаа ёс зүйн гэрээ хийсэн,	
2.4.2	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон талт хамтын ажиллагааг өргөжүүлж, хүчирхийллийг бууруулна.	Сумын гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зөвлөл. (ГХУСЗ). Хамтарсан баг болон ТББайгууллагатай хамтран зохион байгуулсан танхим ба онлайн сургалтанд тухайн бүрд хамаарсан байна. Сумын албан байгууллагын ажилчид, ард иргэдэд нийт багийн Засаг дарга нартай хамтран ажиллаж гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн сурталчилгааны гарын авлага бусад тараах материалыг нийт өрхийн 60% тараасан болно. 11, 1-р багт БЗД-тай хамтран зарим айл өрхөд хэсэгчлэн болон бүлэг, ганцаарчилсан ГБТ тухай хууль болон бусад нийгмийн даатгал, халамж гэх мэтийн хуулийн сурталчилгаа хийв. Үүнд нийт 75-аад өрхийн 124 гаад иргэн хамаарав.	100%
2.4.3	Залуу гэр бүлийг бодлогоор дэмжинэ.	Залуу гэр бүлүүдийг хамруулан “Гэр бүлийн өдөрлөг” болон “Гэр бүлийн эерэг харилцаа” агуулгын хүрээнд мэдээлэл өгөх талаар Хөх сэрхийн тусгай хамгаалалтын газартай хамтран сургалт зохион байгуулж, сурталчилгааны материал тараав. Сумын ЭМТ-ийн нийгмийн ажилтантай хамтран залуу ээжүүдэд	100%

		“Гэр бүлийн төлөвлөлт” сэдвийн сургалт залуу гэр бүлд зөвлөгөө өгөх эвлэрүүлэн зуучлах эерэг харилцаа хүмүүжлийн талаар сургалтыг зохион байгуулж ажиллаж байна. Үүнд нийт 57 хүн хамаарсан байна.	
2.4.4	Аливаа хэлбэрийн хүчирхийллээс сэргийлэх чиглэлд хяналт тавьж ажиллана.	Сумын хэмжээний ард иргэдийг аливаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд тухайн бүрд холбогдох ажилтантай хамтран хяналт хийж тухайн үед гарсан дутагдлыг арилгах талаар заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.	70%

ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР

3.1 Зорилтот бүлгийн өрх, иргэдийн нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулна.

3.1.1	Зорилтод бүлгүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлнэ.	Өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх зорилгоор 05-р сарын 29-ний өдрөөс 06-р сарын 5 өдрийг хүртэл бүх багуудаар судалгаа хийж амьжиргааны түвшин доогуур , зорилтод бүлгүүдийн амьжиргааг дэмжих, хүнсний талонд хамруулах арга хэмжээ авч ажиллалаа.	100%
-------	--	---	------

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

4.1 Санхүү, төсвийн бодлого

4.1.1	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийн сахилга батыг сайжруулж, хэмнэлтийн горимд шилжүүлэн, хариуцлагыг дээшлүүлнэ	Жилийн эхэнд төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэн ажиллах талаар сургалт зохион байгуулж, үүрэг даалгавар өгч ажилласан. Төсөвт байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайланг Холбогдох материалуудын хамт Аудитын газарт хуулийн хугацаандаа хүргүүлж, дүгнэлт гаргуулан зөрчилгүй ажиллаж байна. Батлагдсан төсвийг эдийн засгийн зориулалтын дагуу зарцуулах, хэмнэлттэй ажиллах талаар төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт санхүүгийн албаны мэргэжилтнүүд арга зүйн зөвлөгөө өгч тогтмол хяналт тавьж ажилласны үр дүнд төсөвтэй холбоотой зөрчил гараагүй болно.	100%
4.1.2	Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэн татварын үйлчилгээг иргэд, татвар, төлөгчдөд хүндрэлгүй болгох.	Төрөл бүрийн албан татварын орлогыг бүрэн хурааж, төлбөр хураамжийн орлогыг урьд оны түвшингээс нэмэгдүүлэн төвлөрүүлж ажиллаж байгаа. Татварын орлого жилийн эхэнд 2,049,972.8 сая төгрөгөөр төлөвлөгдөж 11 сарын 30-ны өдрийн байдлаар 1,756,434,511 төгрөгийн орлого орсон. Татварын орлогыг жигд биелүүлж, урьд оны түвшингээс илүү төвлөрүүлэх тооцоотой ажиллаж байна. Татварын хуулиудыг сурталчлах ажлыг эрчимжүүлж татварын байцаагч, төрийн сангийн мэргэжилтнүүдийг	100%

		сургалтанд хамруулж, хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байгаа болно. Сумд жил бүр татварын хууль, гарсан тушаал шийдвэрүүдийг татвар төлөгч иргэдэд сурталчлан ажиллаж байна. Төсөвт байгууллагууд, ААН-д шинээр нэвтрүүлж байгаа е баримт системийг ашиглах, түүнийг ажилдаа мөрдлөгө болгоход байнга зөвлөгөө өгч ажиллав. Жилийн эхнээс төлөвлөгөө гарган ажилласны үр дүнд татварын орлого нэр төрлөөр нь биелэгдэж байна.	
4.1.3	Нийгмийн даатгалд датгуулах, тэтгэвэр тэтгэмжийг олгох үйлчилгээг шуурхай болгох	Нийгмийн даатгалын хамрах хүрээ жил бүр тэлж, малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, сайн дурын даатгалд хамрагдагч нар тухай бүр гэрээ хийлгэж тооцоогоо хийж байгаа. Сар бүр өндөр нас, тахир дутуу, тэжээгч алдсаны тэтгэврийг сарын 01-ний өдөр олгож байгаа. Энэ жил давхардсан тоогоор 13200 хүнд 6.751.500.000 төгрөг тэтгэврийг хурдан шуурхай чийрэгдэлгүй олгосон. Тэтгэмжийг цаг хугацаандаа олгож байгаа. Энэ жил 250.000.000 төгрөг тэтгэмж, 90 сая төгрөгийн оршуулгын тэтгэмж олгосон болно.	100%
4.3 Тогтвортой хөдөө аж ахуй			

4.3.1	Орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	2023 оны Нийгмийн халамжийн сангаас Оёдол-2 хүнд 8 сая, Гоо сайхан-1 хүнд 5 сая, Модон эдлэл 1 хүнд 5 сая, Гагнуур 1 хүнд 5 сая, малжуулах төсөл 4 хүнд 20 сая төгрөгийн төсөлд хамруулж шинээр 9 хүний ажлын байр бий болсон байна.	90%
4.3.2	Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, сайжруулах замаар бэлчээрийн менежментийн нэгдсэн системийг бий болгоно.	Энэ жилийн хувьд сумын 1-р багийн газар нутагт бэлчээрийн 2 худгийг ОНСангийн төсвөөр засвар хийж гүйцэтгэж, 7-р багт аймгийн ОНСангийн хөрөнгөөр бэлчээрийн худгийг шинээр малтаж ашиглалтад оруулсан байна.	100%
4.3.3	Бичил, жижиг, дунд үйлдвэрийн чадавхыг бэхжүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлнэ.	Жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн эрхлэгчдийн худалдаа , борлуулалтыг дэмжих зорилгоор ЖДҮЭрхлэгч нарыг 2 удаагийн сургалтад хамруулж, Намар 2 удаа үзэсгэлэн худалдаанд оролцуулж бодлогоор дэмжин ажиллаж байна.	100%
4.3.4	Байгаль, экологи, бэлчээрийн даацтай уялдуулж малын тоо, төрөл, бүтцийн дээд хязгаарыг тогтоох, бэлчээрийн мэрэгч амьтад, хөнөөлт шавьжтай тэмцэх, малын бэлчээр хадлан тэжээл, усны хангамж хэрэгцэг нэмэгдүүлж мал аж ахуйн	Бүх багийн хурлаар явж малчидтай уулзаж бэлчээрийн зохицтой ашиглах малын тоо толгойг цөөлөх, малын чанарыг сайжруулах, мэрэгч амьтадтай тэмцэх талаар ярилцаж, мэрэгч амьтад хөнөөлт шавьж тархсан тохиолдолд авах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх талаар зөвлөж хамтран ажиллав.	100%

	эрсдэлийг бууруулна.		
4.4 Газрын харилцаа			
4.4.1	Иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн цахим систем, газрын кадастрын нэгдсэн ухаалаг системүүдийг нэвтрүүлнэ.	Ажил хийгдээгүй байна.	0%
4.4.2	Нутаг дэвсгэртээ хамаарах геодезийн цэг, тэмдэгтүүдийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, тооллого хийх, устсан цэг тэмдэгтийг сэргээг засварлаж, нутаг дэвсгэрийн бүх төрлийн байр зүйн зургаар хангана.	Сумын хэмжээнд байгаа геодезийн цэг тэмдэгтийн тооллогоор 16 цэг устсан ба түүнийг нөхөн сэргээхэд 6,5 сая ОНХСангийн хөрөнгөөр шийдвэрлэгдсэн ба 2022 онд 7 цэгийг нөхөн сэргээсэн болно. 2023 онд төсөв хүрэлцэхүйгүйн улмаас санхүүжилт хийгдээгүй байна.	50%
ТАВ: ЗАСАГЛАЛ			
5.1.1	Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангах замаар	Сумын ЗДТГазрын болон дэргэдэх албанд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад ОНХСан болон Орон нутгийн орлогын давсан хэсгээс 17.7 сая төгрөг шийдвэрлүүлж 3 зөөврийн компьютер, 3ш канон принтер нийлүүлж албан	100%

	авилга, хүнд суртлыг бууруулна.	хаагчдад олгосон. Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 12.0 сая төгрөгөөр БОХУлсын байцаагч болон хоёр байгаль хамгаалагч нарт 3ш зөөврийн компьютер, 1 ш өнгөт канон принтер олгосон байгаа. Сум, орон нутагтаа төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, Нээлттэй мэдээллийн систем / shilen.gov.mn/-ийн мэдээллийг хэвлэн нийтлэх ажлыг эрчимжүүлэх, “ХУРДАН” цэгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, төрийн албан хаагч болон иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж авлига, хүнд сурталыг бууруулан ажиллаж байна.	
5.1.2	Засаглалын бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналтыг иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор сайжруулж, иргэдэд шуурхай хүргэх, сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулна.	Дэлүүн ЗДТГ-ын фейсбүүк хаягаар төрийн бодлого, шийдвэр болсон явдлыг тухай бүрт цахим хэлбэрээр тогтмол мэдээлэн ажиллаж байна. Дэд газраас ирсэн тогтоол шийдвэр, дүрэм журмыг иргэдэд шуурхай хүргэх ажлыг байгууллагын фейсбүүк хаягаар тогтмол хүргэж байгаагаас гадна байгууллагын дарга эрхлэгч, багийн засаг дарга нараар дамжуулан байнга сурталчлах ажлыг явуулж байна.	100%
5.1.3	Төрийн байгууллагуудын цахим хуудсыг шинэчлэх, ашиглалтыг сайжруулан	Е.Монголиа үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй болгож, Цахим засаглал, Эвит программ, онлайн хуралдааны тоног	50%

	мэдээллийн ил тод байдлыг хангана.	төхөөрөмжийг ОНХСангийн хөрөнгөнөөс хуваарилагдсан 5.0 сая төгрөгийн хөрөнгөөр суурилуулахаар шийдвэр гаргасан болно. Сумын цахим хуудсыг бүрэн шинэчилж бүх мэдээ, мэдээллийг тогтмол мэдээлэн ажиллаж байна.	
5.1.4	Аймгийн хэмжээнд "Цахим Монгол" хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг ойртуулах, хялбаршуулан хүргэх нөхцөлийг бүрдүүлж, шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй, ил тод нээлтэй байдлыг хангаж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэнэ.	Алсын хараа-2050 Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримт, "Шинэ сэргэлтийн бодлого-ын "Цахим үндэстэн" зорилт, "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллганы хөтөлбөр", Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон Баян-Өлгий аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээ, "Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/53 дугаар тушаал " Цахим аймаг" бодлогыг сумд хэрэгжүүлэн ажиллаж байна. "Цахим Монгол" хөтөлбрийн хүрээнд хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж худалдан авах хөрөнгийн эх үүсвэрийг сумын ИТХ-ын ээлжит хуралдаанд оруулан шийдвэрлүүлсэн.Төрийн үйлчилгээг иргэдэд хялбаршуулан хүргэх, төрийн үйлчилгээг нээлттэй ил тод байлгах талаар ХУРДАН цэгийн үйлчилгээг эрчимжүүлсэн байна.	100%
5.1.5	Төрийн албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, чадавхжуулах үйл ажиллагааг	Тайлант онд төрийн захиргааны нэг албан хаагч ахлах түшмэлийн, хоёр албан хаагч дунд хугацааны мэргэшүүлэх	100%

	оновчтой болгож, нийгмийн баталгааг хангана.	багц сургалтанд тус тус хамрагдсан. Хоёр албан хаагч дэс түшмэлийн цахим сургалтанд хамарсан бол бүх төрийн захиргааны албан хаагч нар “Үр дүнд суурилсан бодлого,төлөвлөлт,хчналт шинжилгээ,үнэлгээ цахим сургалтанд хамрагдав. Мөн пүрэв гариг болгон зохион байгуулагдсан ТАЗ-ын сургалтанд тогтмол оролцож байв. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулж 17.7 сая төгтөгийн тоног төхөөрөмж авч өгөв,	
5.1.6	Шударга, хариуцлагатай, ил тод, төрийн албыг бэхжүүлж, авлигын бүх хэлбэрийг таслан зогсоож, хяналтыг нэмэгдүүлнэ.	Эдийн засаг, нийгэм, хүн ам, технологийн харилцан хамаарал улам нэмэгдэж, мэдээллийн технологийн хэрэглээ өсөж, шинэ зууны мэргэжилтнүүдийн мэдлэг, чадвар, хандлага өөрчлөгдөж байгаатай уялдуулж сумын төрийн үйлчилгээг шинэ түвшинд гаргах, үүнд чиглэсэн Төрийн албаны шинэчлэл, албан хаагчдын ур чадвар, мэргэшил, чиг хандлага, хөгжлийн түвшин, соёлын онцлогтой уялдуулан хөгжүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж байна. Дижитал шилжилтийн эринд төрийн албыг хэрхэн үр ашигтай зохион байгуулахаас бидний шинэтгэлийн үр дүн ихээхэн хамаарах нь тодорхой юм. Хүнд суртлаас ангид авлигад автахгүй албан үүргээ чанартай гүйцэтгэх уриаг тухайн онд дэвшүүлэн ажилласан ба тайлант жилд авлига авсан, хээл хаахуулд автсан асуудал гараагүй	100%

		болно.Төрийн албан хаагчдаас албан үүргээ гүйцэтгэж байгаа байдал болон авлига албан тушаалаа урвуулан ашигласан талаар иргэдээс ямар нэгэн санал, гомдол гараагүй болно.	
ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ			
6.1. Байгаль орчин			
6.1.1	Хүрээлэн буй орчны бохирдол, хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.	БОАЖ-ын сайдын 2023 оны 02 дугаар албан даалгавар, аймгийн БОАЖ-ын газрын даргын 2023 оны А/03 тоот тушаалыг хэрэгжүүлэх, ажлыг эрчимжүүлэх зорилгоор сумын Засаг даргын 2023 оны 03-р сарын 01-ний өдрийн А/19 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж “Хоггүй орчин-Эрүүл амьдрал” аяныг үргэлжлүүлэн зохион байгуулан ажиллав. Үүнд: - Аяныг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган ажлын хэсэг байгуулан аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулав. - Суманд үйл ажиллагаа эрхлэн явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд, иргэдэд аяны талаар бичгээр болон цахим хэлбэрээр мэдээлэл хүргэх, танилцуулах ажлыг ажлын хэсгийн гишүүд амжилттай зохион байгуулав.	80%

		- Дэлгүүр, аж ахуйн нэгж, байгууллагад 50 метр хүртэлх талбайн хилийн заагийг тогтоож их цэвэрлэгээ хийлгэх мөн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг цуглуулах ажлыг зохион байгуулав. - Сумын төвийн эргэн тойрны болон шуудууны доторх үхэж хорогдсон мал амьтны сэг зэмийг цуглуулан устгах, булах ажлыг зохион байгуулан ажиллав. - Сумын төвийн орчны нийтийн эзэмшлийн газрыг ААН, байгууллагуудад хувиарлан хариуцуулж цэвэрлүүлэх ажилд хяналт тавьж ажиллав. - Эзэнгүй хог хаягдал, хууль бус хогийн цэгүүдийг цэвэрлэх, дарж булах хаах, тэнд хог хаяхыг хориглосон самбар байршуулах, ажлыг зохион байгуулан ажиллав. - ААН, байгууллагын дотор болон гадна талбайд стандартын шаардлага хангасан хогийн савыг байршуулахыг дарга, эрхлэгчдэд шаардлага тавьж ажилласан болно. Багийн төв, өвөлжөө, хаваржааны эзэмшил газарт их цэвэрлэгээ хийлгэн хогийг зайлуулах, сэг зэмийг устгах ажил хийлгэхийг багийн засаг дарга нарт албан даалгавар өгч хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав. -Бага сургуультай 5, 10-р багийн төвийн айл өрхүүдэд ажлын	
--	--	---	--

		хэсэг мэдэгдэл тарааж хог хаягдлаа цэвэрлэх, их цэвэрлэгээ зохион байгуулах, тогтоосон хогийн цэгт хур хогоо хаяхыг мэдэгдэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв. - Худаг эзэмшигчдэд орчны болон дотоод ариун цэврийг сайжруулан худгийг цагийн хуваарийн дагуу ажиллуулах талаар анхааруулан ажиллав. - Нийт айл өрх, ААН, байгууллагын орчны бохирдолд 7 хоног бүр хяналт шалгалт хийж ажилласан болно. - 6-р сард аймгийн ХХҮГ-ын дэмжлэгтэйгээр 10 хоногийн хугацаатайгаар 6 хүн авч ажиллуулан мал, амьтны сэг зэм устгах ажлыг зохион байгуулав. Сумын орчмын нийтийн эзэмшил газар болон гол, булаг шандаас нийт 18 пронтер машин буюу 26 тн мал, амьтны сэг зэм болон бусад хог хаягдлыг ачиж цуглуулан зөвшөөрөгдсөн цэгт нүх ухаж ариутгал халдваргүйжүүлт хийж булсан болно. Мөн багийн засаг дарга нар болон ААН, байгууллагуудын дарга эрхлэгч нарт сар бүр тогтмол орчны хур хог хаягдлыг цэвэрлэх тухай үүрэг даалгавар өгч байсан болно. Төрийн байгуулага болон иргэдэд мэдэгдэл хүргүүлж дараах ажлуудыг гүйцэтгүүлж хэрэгжилтэнд хяналт тавьн ажиллаж байна.	
--	--	--	--

		Үүнд: 1. Хог хаягдлын тухай хуулийн 9-р зүйлийн 9.4.12-т зааснаар аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын болон эзэмшил газрын хогийг сар бүр тогтмол их цэвэрлэгээ хийх 2. Үнс хог хаягдлаа сумын нэгдсэн хогийн цэгт хаях 3. Бохир усаа ир задгай асгахгүй бай, хог хаягдлаа задгай хаяхгүй байх 4. Байгууллага бүр стандартын шаардлага хангасан хогийн сав байрлуулах зэрэг	
6.1.2	Сумын хэмжээнд ногоон байгууламжийг шинээр бий болгон нэмэгдүүлнэ	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд мод тарих хашааг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр өргөжүүлэн, хаврын мод тарилтаар 3500 ш үүний: улиас 2000 ш, бургас 1500 ш, намрын тарилтаар 5000 ш суулгац үүний: чацаргана 4000 ш, улиас 500 ш, бургас 500 ш тус тус тарьсан болно.	100%
6.1.3	Байгалийн унаган төрхөө хадгалсан газрын	Тус суманд байгалийн баялаг нөөц хамгаалах чиглэлээр 4 нөхөрлөл үйл ажиллагаа явуулдаг ба байнга дэмжлэг	90%

	орон нутгийн тусгай хамгаалалтад авна.	үзүүлэн хамтран ажиллаж байгаа болно. Байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад БОХУ-ын байцаагч, байгаль хамгаалагч, Эко клубийн ажилтан, багийн Засаг дарга нар болон бусад холбогдох албан хаагчдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	
6.1.4	Уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийн нөхөн сэргээлтийн ажлуудыг бүрэн хангана.	Суманд хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 4 аж ахуйн нэгж хайгуулын үйл ажиллагаа явуулдаг ба хайгуул хийсэн талбайн нөхөн сэргээлтийг бүрэн хийж хүлээлгэн өгч байна.	80%
6.1.5	Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	Мод үржүүлэх, ойжуулалт, ойн зурвас, суурин газрын цэцэрлэгжүүлэлтийн зориулалтаар ажил хийх хүсэлт ирүүлсэн “ЭКО АЙЛ” бүлгийн 6 иргэнд Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжсэн 9 га талбай бүхий хашааг хугацаат гэрээгээр хариуцуулан орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган, холбогдох хууль, журмын дагуу ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Өнөөдөрийн байдлаар уг хашаанд нийтдээ 8.5 мянган гаруй мод тарьж ургуулж байна. Эко айл бүлэг 2024 оны хаврын тариалалтаар нарийн ногоо, хүнсний ногоо, ногоон тэжээл тарьж туршилт хийж үзэхэд ургацын	90%

		гаралт 80% тай байсан. Энэ жилээс эхлэн төлөвлөгөө гаргаж гүний худаг гаргах, өвлийн хүлэмжтэй болгох ажил хийгдэхээр тооцоо судалгаа гарган ажиллаж байна.	
6.1.6	Усны сан бүхий газар болон ус хангамжийн эх үүсвэрүүдийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомстлоос сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлнэ.	Тус сумын төвийн хүн амны ундны усны эх үүсвэр нь гүний худаг байдаг. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ирсэн мэргэжилтнүүдтэй хамтран Усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэм мөрдөх талаар ИТХ-ын төлөөлөгч болон ард иргэдэд сургалт зохион байгуулж, сурталчилгааны материал тараасан.	90%
ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ			
7.1.1	Цэргийн насны залуучуудын эрүүл мэндэд анхаарч, иргэн цэргийн харилцаг бэхжүүлнэ.	2024 оны ээлжит цэрэг татлагын ажлыг 2 удаа зохион байгуулж нийтдээ 16 цэрэг цэргийн жинхэнэ албанд татагдсан. Сумын 2024 оны А/29, А/74 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг маш сайн зохион байгууллаа. Цэргийн албанд татагдах 18-25 насны хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэнүүдэд оршин суугаа газраас нь үл хамааран зарлан дуудах мэдэгдлийг хүргүүлэн ажилласан.	100%

		Цэргийн албанд татагдахаар тэнцсэн залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулахад 6 залуугийн эрүүл мэндийн байдлаас болж буцаасан ба 5 дугаар сард 3 залуу, 10 дугаар сард 13 залуу цэргийн албанд татагдан алба хааж байна. Цэргийн албанд татагдсан залуучуудтай байнга холбогдон ар гэрийн хүмүүст мэдээлэн ажиллаж байна. Сумын хэмжээнд иргэн цэргийн харилцаа сайжирч цэргийн албанд явах хүсэлтэй залуучууд нэмэгдэж байна.	
7.1.2	Гэмт, хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, гэмт хэргийн гаралтын түвшинг бууруулна.	Ерөнхий боловсролын 1-р сургуулийн ахлах ангийн 56 сурагчид "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" яриа хийсэн ба авлигын талаарх 3 видео бичлэг үзүүлэн авлигын гэм хорын талаар яриа хийж ажиллав. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд сахилга хариуцлагыг эрс сайжруулах, ямар нэгэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд зориулж сумын 5 газарт камер байршуулсан.	100%
7.1.3	Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ.	Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг аймгийн Онцгой комиссоос үүрэг болгосны дагуу байнга шинэчлэн томилгоожуулан ажиллаж байна. Сумын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд 66 хүн үүрэг гүйцэтгэж байгаа. Хөдөө багийн хоёр бага сургуулиас 12 албан хаагчийг нөөцөд нэмж 78	100%

	албан хаагчийг ажиллуулахаар төлөвлөгөөнд оруулан ажиллаж байна. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд багтсан албан хаагчдын нийгмийн баталгаа, аранз, дулаан хувцас, бэлэн байдлыг ханган ажиллах чиглэлээр төрийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарт үүрэг даалгавар өгч ажилласан. Хөдөө багт үйл ажиллагаа явуулдаг 2 бага сургуулийн 12 албан хаагчийг нөөцөд бэлдэж тухайн багуудад ямар нэгэн эрсдэлт, гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэн ажиллах талаар иргэдэд байнга заавар зөвлөгөө өгч уялдаа холбоотой ажиллуулах талаар хоёр бага сургуулийн захирал нарт үүрэг даалгавар өгч ажиллаж байна. Сумд үйл ажиллагаа явуулдаг Эрэн хайх, аврах бүлгийн албан хаагчид мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд байнга зөвлөгөө өгч, мэргэжлийн арга зүйгээр ханган ажилладаг. Төрийн байгууллагуудын 3 пургон, 1 пикап машиныг байнга бэлэн байлгаж байна. Хувийн иргэдийн туулах чадвартай 10 тээврийн хэрэгслийг онцгой үед дайчлах талаар хэлэлцээ хийсэн.	
Ерөнхий дүн:		89.5%

БИЕЛЭЛТ ГАРГАЖ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

К.САНДГҮЛ

ХЯНАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА

С.АМАНКЕЛД